



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар

102

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан "Жижиг дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх хяналт тавих журам"-ын 11.5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан хөнгөлөлттэй зээл олгох Ерөнхий нөхцөл, салбар, чиглэлийн дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг хүлээн авч дууссантай холбогдуулан "Жижиг дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх хяналт тавих журам"-ын 1.4, 5.9 дүгээр зүйлд заасан шалгуур хангаж буй эсэх болон ирүүлсэн материалын иж бүрдлийг шалгах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Мөнхбаяр (Хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Ш.Оюун (Монголын тогооч нарын холбооны Дундговь дахь салбарын тэргүүн)

С.Өлзийсайхан (Баялаг бүтээгчдийн холбооны Дундговь дахь салбарын дэд тэргүүн)

2. Албан үүргийн дагуу олж авсан мэдээллийн нууцыг хадгалах, өөрийн болон бусдын ашиг сонирхолд ашиглахгүй байх, төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан сахиж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч болон гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.МӨНХЖАРГАЛ



48231 030